



178 Page



179 Page



180 Page

Елиа

- Elijah-

Тайлбарлагч Энэ бол Ахаб хаан Израилийг захирч байх үед болсон явдал ажээ. Ахаб хаан Бурханд итгэдэггүй бөгөөд харин Баал шүтээнд мөргөдөг байв. Яг энэ үед Бурхан Израильчууд уруу эш үзүүлэгч Елиаг илгээв.

Елиа Харийн шүтээнд хүндэтгэл өргөж болохгүй. Бид цор ганц Бурхандаа л хүндэтгэл өргөх ёстой.

Тайлбарлагч Елиа Бурханы үгийг ард түмэнд дамжуулдаг хүн байв.

Бурхан Босож, Сидонд харьяалагддаг Зарефат уруу яваад, тэндээ бай.

Елиа За, ойлголоо Бурхан минь.

Тайлбарлагч Нэгэн өдөр, Бурхан Елиад Зерафат уруу оч гэж тушаав. Тэнд нөхрөө алдсан нэгэн эмэгтэйтэй уулзах болно гэв.

Елиа За байз... Зерафат хаана байдаг билээ...

Тайлбарлагч Удалгүй Елиа модны мөчир түүж байгаа эмэгтэйтэй таарчээ. Тэр өнөөх бэлэвсэн эмэгтэй мөн байв. Тэгээд Елиа тэр эмэгтэйд ингэж хэллээ.

Елиа Надад уух ус, зүсэм талх авчирж өгөөч.

Тайлбарлагч Тэр эмэгтэй Елиаг хараад Бурханы явуулсан хүн гэж мэджээ. Харин тэр маш ядуу байсан учраас Елиагийн гүйсан зүйлийг өгөх хэцүү байлаа.

Бэлэвсэн эмэгтэй Надад талх байхгүй. Зөвхөн миний хул аяганд атгын төдий гурил, вааранд минь жаахан тос үлдсэн. Харагтун, би гэртээ харьж, өөртөө болон хүүдээ зориулан хоол хийхийн тулд одоо түлээ түүж байна. Дараа нь бид үхэх байх даа.

Тайлбарлагч Энэ эмэгтэйн амьдрал маш хэцүү байдалд байгааг Елиа мэдэж байлаа.

Елиа Би таныг ямар байдалтай байгааг мэдэж байна. Эхлээд байгаа зүйлээрээ идэх юм хийгээд авчирж өгөөч. Тэгвэл Бурхан, танай гурил болон тосны савыг үргэлж дүүрэн байлгаж ерөөх болно.

Тайлбарлагч Бэлэвсэн эмэгтэй, Елиагийн хэлснээр хийжээ. Гэтэл Израильд болсон гурван жил зургаан сар үргэлжилсэн ган ганчиг тайлагдах үе хүртэл бэлэвсэн эмэгтэйн гурил болон тосны сав дүүрэн байжээ. Тэр эмэгтэйн гэрт Бурханы ерөөл буусан нь тэр байлаа.



181 Page

Тайлбарлагч Гэтэл нэгэн өдөр бэлэвсэн эмэгтэйд гунигтай зүйл тохиолджээ. Эрүүл байсан хүү нь өвчинеэс болоод гэнэт нас барсан байлаа. Эмэгтэй Елиад хандан ингэж хэлжээ.

Бэлэвсэн эмэгтэй (гунигтай хоолойгоор) Яагаад намайг ингэж их зовоогоод байгаа юм бэ? Та надтай ямар хамааралтай болоод миний гэмийг сануулж, миний хүүг үхүүлэхээр ирсэн юм бэ?

Тайлбарлагч Эмэгтэй Елиад хандан ингэж хэлээд уйлжээ. Елиа үхсэн хүүг дээд давхрын өрөөнд оруулан хэвтүүлээд Бурханд хандан залбирчээ.

Елиа

Бурхан минь, энэ бэлэвсэн эмэгтэйн хүүг юунд үхэлд хүргээ вэ?

Тайлбарлагч Елиа, үхсэн хүүгийн дээр гурвантаа алдлан хэвтээд Бурханд хандан дахин залбирчээ.

Елиа

Бурхан минь, хүүгийн амийг буцаан өгөөч гэж би Танаас гүйж байна.

Хүү

Ёох, өлсөж байх чинь. Ээжээ надад хоол өгөөч.

Тайлбарлагч Бурхан, Елиагийн залбирлыг сонсоод үхсэн хүүг амь оруулсан байжээ. Бэлэвсэн эмэгтэй хүүгээ тэврээд уйлж байлаа. Тэгээд Елиагийн өмнө сөхөрч суугаад:


Бэлэвсэн эмэгтэй

Одоо л би таныг Бурханы хүн гэдгийг мэдэж, таны аманд буй ЭЗЭНий үг үнэн болохыг ойлголоо.

Тайлбарлагч Бэлэвсэн эмэгтэй Бурханд талархаар байв.



182 Page



183 Page



184 Page